

хэрэгжүүлэх нь үйл ажиллагаа ба сургалтын салшгүй хэсэг бөгөөд болзошгүй эрсдэлд сөрөг няцаалт өгөх чадварыг баталгаажуулах чухал хүчин зүйл, итгэл үнэмшил болж өгнө.

Хэрхэн яаж өөрчлөгдөх өсөх үү, буурах уу гэдэг нь бэлтгэл сургуулилын чанараас хамаарах нь зайлшгүй, бодит байдалд ойртсон төрөл бүрийн орчинг бүрдүүлсэн нөхцөлд бэлтгэх нь жинхэнэ үйл ажиллагаанд сандарч балмагдах нь бага байхаас гадна, хүртэхүй, сэтгэхүй, анхаарал, ойн оператив шинжид илрэх сөрөг үзэгдэл бага байна.

Сэтгэл зүйн бэлтгэл нь түүний хувийн бэлтгэлээр хязгаарлахгүй хамт олны нөлөөлөл, төлөвшилт, хоорондын харьцаа, дулаан уур амьсгал зэрэг нь сэтгэл зүй, бие бялдарын хөгжлийн түвшинг ихээхэн чанаржуулдаг. Нэгдэл нягтралтай эвсэг хамт олны доторх бэлтгэл сулхан гишүүн ч өөрийгөө итгэлтэй үнэлж, учирсан бэрхшээлийг зоримгоор давж туулдаг нь олонтаа. Иймд нөхцөл байдалтай уялдуулан хамт олны сэтгэл зүйн таатай уур амьсгалыг төлөвшүүлэх, тэдгээрийг удирдах нь чухал юм.

* * *

О.БАЯРЖАРГАЛ

*Шүүхийн шийдвэр
гүйцэтгэлийн
сургуулийн Нийгмийн
ажлын тэнхимийн
багш, ахлах дэслэгч*



СУЛЛАГДАХ ЯЛТАНД ҮЗҮҮЛЭХ НИЙГМИЙН АЖЛЫН ОНОЛЫН ҮЗЭЛ БАРИМТЛАЛ

Ял, түүний зорилгын талаарх үзэл баримтлал, хандлага: Германы эрүүгийн эрх зүйн орчин үеийн буюу өнөөгийн онолд ялыг гэмт үйлдэл хийсэн гэм буруутай этгээдийн эрх зүйн үр дагавар гэж тодорхойлсон байдаг. Тодруулбал, хуучны уламжлалт ойлголтоор ялын мөн чанарыг "хариу авах" эсвэл айлгах, эмээлгэх гэсэн агуулгаар авч үзэхээс аль болох татгалзаж харин хор уршиг учруулна гэдэг нь шударга ёс биш хэмээн тунхагладаг хуульчдын номлол хүчтэй давамгайлдаг.

Тиймээс ч Германы Эрүүгийн хуулийг Европын улсууд дотор хамгийн "зөөлөн" хуульд оруулдаг нь ялын бодлоготой нь шууд холбон тайлбарлаж болно. Ялын мөн чанарыг танин мэдэхийн тулд түүний зорилгыг тодорхойлох ёстой. Уламжлалт номлол сургаалд ял нь зорилготойгоо хэрхэн уялдаж байгаагаар түүний ойлголтыг тодорхойлж байсан.

Ялангуяа 19-р зууны Германы эрүүгийн эрх зүйн номлолд ял ба түүний зорилгын харилцан хамаарлыг судлан ялын туйлын ба харьцангуй онолыг бий болгосон. Туйлын онолын үүднээс авч үзвэл ялын гол зорилго нь хариу авах аргаар тодорхойлогдоно

гэсэн бол харьцангуй онолоор ялыг гэмт хэргээс урьдчилан сэргийлэх, хүмүүжүүлэх хамгийн сайн арга хэмээн үзсэн байдаг.

Суллагдах ялтанд нийгмийн ажлын үйлчилгээ үзүүлэхэд чадваржуулах онолыг ашиглах нь:

Чадваржуулах онолын үзэл баримтлал нь нийгмийн үйлчилгээний олон байгууллагын үйл ажиллагааны удирдах зарчим нь болдог. Ялангуяа ял эдэлж буй ял эдлэгсдийн хувьд тэднийг чадваржуулах гэдэг нь бусадтай харилцах харилцаа холбоогоо таслахгүйгээр өөрийн амьдралдаа эзэн нь болж бие даасан байдлаа хангах чадвартай болохыг хэлдэг (Garza, 2002, 27 p). Мөн чадваржуулах онол нь хүмүүс амьдралдаа тохиолдсон бэрхшээлтэй асуудлаа шийдэх үйл ажиллагаанд идэвхтэй оролцох замаар өөрийн амьдралын чанараа сайжруулна гэсэн санааг дэвшүүлсэн. Гол нь чадваржуулах үйл явц нь өөрийгөө буруутгалгүйгээр юу хийж чадах, юуг хянаж чадахгүй хийсэн үйлдлийнхээ төлөө ямар хариуцлага хүлээх ёстой талаар ойлгоход нь тусална (Gorza, 2002).

Чадваржуулах хандлагад хүнд туслах үйл ажиллагааг дэмжих хувь хүний биеэ авч явах байдал, итгэл үнэмшлийн буруу хандлага, гадаад орчны бэрхшээл ба хэрэгцээтэй үл нийцэх тогтолцоо зэргийг өөрчлөн, хүмүүсийн амьдралын бахархал, итгэл үнэмлшийг бий болгох, асуудал тавих шийдэх, ухамсрыг нэмэгдүүлэх, харилцан ярилцах бүлэг, олон нийтийг бүрдүүлэх үйл ажиллагаа багтана.

Парсон болон Симон нар чадваржуулалт нь хувь хүн, гэр бүл, бүлэг, олон нийтийн эрх мэдлийг

хөгжүүлж, дээшлүүлэхэд чиглэгдсэн үйл явц юм гэж тодорхойлсон (Parson & Cox, 1994 p 4). Хүмүүсийг чадваржуулах гэдэг нь тодорхой үнэт зүйлд тулгуурлан явуулах үйл ажиллагаа. Эдгээр үнэт зүйлүүд нь хүмүүсийг ялгаварлахгүй байх, аливаа ялгааг үл харгалзан тэднийг хүндэтгэх үнэт зүйл, тэгш эрх, боломж олгох, шударга ёсыг хангах зорилгыг агуулж байдаг.

Нийгмийн ажлын практикийн чадваржуулах үйл ажиллагаа нь үндсэн дөрвөн бүрэлдэхүүн хэсэгтэй. Үүнд:

1. Хандлага, үнэт зүйлс, итгэл үнэмшил: Чадваржуулах үйл явцдаа хоригдогчийн итгэл үнэмшил, хандлага, үнэт зүйлсийг харгалзан үзэх нь чухал. Учир нь хоригдогчийн өөртөө итгэх, өөрийгөө таних, өөрийнхөөрөө байх, өөрийгөө хүлээн зөвшөөрөх гэх мэт чадварыг нь дэмжиж хөгжүүлснээр тухайн хүн өөрөө чадваржаад зогсохгүй эргээд нийгэмд ч тодорхой хэмжээгээр үр нөлөө үзүүлдэг байна.

2. Хамтын туршлагаа баталгаажуулах: Хүмүүс бие биенээсээ суралцах, тусламж дэмжлэг хүсэх, асуудлыг шийдвэрлэх шинэ чадварт суралцах, өөртөө итгэлтэй байх зэрэг нь хоорондын харилцааны явцад хөгжиж, харилцан туршлага солилцох нөхцөл болдог. Харилцааны явцад өөрийн болон ойр тойрныхоо нөхцөл байдлыг таньж мэдснээр үйлчлүүлэгчийн өөрийгөө буруутгах үзэл нь багасаж, аливаа асуудлын учир шалтгааныг зөвхөн хувь хүнээс биш олон талаас нь харах чадвартай болдог.

3. Шүүмжлэлтэй хандаж ажиллах мэдлэг, ур чадвар: Хоригдогч бусдын дэмжлэг, тусламжтайгаар өөрийн

асуудлын дотоод, гадаад хүчин зүйлүүдийг шүүмжлэлтэйгээр эргэцүүлэн бодно. Асуудлыг улс төр, нийгмийн орчинд нь бодож тунгааснаар өөрийн итгэл үнэмшил, хандлага ойлголт нь хаанаас нь гарч ирсэн, үүнд юу нөлөөлж байгаа болохыг мэдэж, мэдээлэл олж авах, үйл ажиллагаанд оролцох байдлаар үйлчлүүлэгчийн чадваржих үйл явц нэмэгдэж хөгжинө.

4. Өөрчлөлт хийх үйл явц Өөрчлөлт хийх оролдлого нь нөөцөөс хүртэх, бүтцийн дотоод, гадаад байдалд нөлөөлөх мэдлэг чадвараа дээшлүүлэх, нийтлэг эрх ашиг, зорилгын төлөө байдаг нийгмийн амьдралд хувь нэмрээ оруулах, үйл ажиллагаанд хяналт тавих үйл явцыг чадваржуулах практик агуулж байна.

Чадваржуулах үйлчилгээний элементүүд: Чадваржуулах практикийн загвар нь үнэт зүйлд түшиглэсэн үйлчилгээ, арга зүйг дэмжсэн, онолд тулгуурласан нийгмийн ажилтан, үйлчлүүлэгч хоорондын харилцаа буюу дэмжин туслах үйл ажиллагааны хүрээ юм. 1976 онд Соломон нийгмийн ажилтнууд үйлчлүүлэгчийг чадваржуулахдаа дараах 4 зорилгуудаас хамгийн багадаа нэг зорилгыг үйлчилгээ, арга зүйнхээ (интервенц) зорилгоо болгох саналыг дэвшүүлсэн (Parson & Cox, 1994 p13).

Үүнд:

1. Асуудалтай холбоотой нөхцөл байдлаа үйлчлүүлэгч өөрчлөх арга замыг олж харахад нь туслах,
2. Үйлчлүүлэгч мэргэжлийн мэдлэг, ур чадвар бүхий нийгмийн ажлын үйлчилгээг ашиглахад нь туслах,
3. Практикийн ажилтнууд асуудлыг шийдвэрлэхэд нөлөө бүхий хамтрагч

мөн гэдгийг ойлгоход нь туслах,

4. "Хүч чадалгүй байх" гэдгийг үйлчлүүлэгч ойлгоход нь туслах.

Суллагдах ялтанд үзүүлэх нийгмийн ажлын үйлчилгээнд давуу талд тулгуурлах хандлагыг ашиглах нь

Хүн бүхэн зорилго тэмүүлэлтэй, авъяас чадвартай байдаг. Түүнчлэн хүнийг агуулж буй орчин нь ямарваа нэгэн нөөц боломж, дэмжин туслах харилцаа холбоог өөртөө багтаасан байдаг. Давуу талд тулгуурлан нийгмийн ажлын үйлчилгээ үзүүлэх үзэл баримтлал нь:

- Сул тал, хүндрэл бэрхшээлээс илүү давуу тал, нөөц боломжийг эрэлхийлэх
- Бэрхшээл саадыг тоочихоос илүү боломжит олон хувилбарыг гаргах
- Үйлчлүүлэгчийн эмгэг, доголдолтой байдлыг тодорхойлохоос илүү сайн тал, авъяас чадварыг нээн хөгжүүлэхэд ач холбогдол өгөх бодит орчинг бүрдүүлэх боломжийг олгодог.

Давуу талд тулгуурлана гэдэг нь хүний амьдралд нөлөөлж буй хүчин зүйлс ба түүнийг эерэгээр өөрчилж, хөгжүүлж чадахуйц арга замыг эрж хайх явдал юм. Нийгмийн ажлын үйлчилгээний үнэлгээ, хэрэгжилтийн үе шатанд нийгмийн ажилтны анхаарлыг үйлчлүүлэгчийн давуу талд хандуулна. Ингэснээр тулгамдсан асуудлаа шийдэх, зорилгоо биелүүлэхэд дөхөм болдог.

Энэхүү хандлага нь суллагдах ялтантай ажиллах үед хэрэглэхэд тохиромжтой. Ерөнхийдөө давуу талд тулгуурлах хандлага нь үйлчлүүлэгчийн давуу тал, хүч нөөцийг илрүүлж, үнэлэх бөгөөд түүнд тулгуурлан үйлчилгээ

хүргэхэд чиглэгддэг. Үйлчлүүлэгчийн давуу тал нь түүний хандлага, туршлага, чадвараар тодорхойлогдоно. Энэ хандлагын гол санаа нь үйлчлүүлэгч бүхэнд давуу тал, хүч нөөц байна гэж үзэх бөгөөд түүнийг илрүүлж, хөгжүүлэх нь нийгмийн ажилтны үүрэг юм. Мөн үйлчлүүлэгчийн давуу талыг урьдчилан харсанаар үйлчлүүлэгчийн өөрийгөө хүндэтгэх үзлийг нэмэгдүүлэхэд туслана. Энэ хандлага нь "чадваржуулах" гэх ойлголттой тун ойролцоо агуулгатай.

Баркер чадваржуулалтыг тодорхойлохдоо "хувь хүн, гэр бүл, олон нийтийн дотоод хүч нөөц, нийгэм эдийн засаг, улс төрийн давуу талыг нь нэмэгдүүлэхэд туслах үйл явц бөгөөд эдгээр нөхцөл байдлыг сайжруулах замаар тэдний "хөгжидд нөлөөлөх явдал юм" гэжээ.

Давуу талд тулгуурлах хандлагыг Сэлибэй 1997 дараах үндсэн 5 таамаглалаар тодорхойлсон. Үүнд: Хувь хүн, гэр бүл, бүлэг, олон нийт бүрт өөр өөрийн давуу тал бий. Сэлибэйн тэмдэглэснээр үйлчлүүлэгч нийгмийн ажилтнаас дараах асуултын хариултыг хүлээж байдаг. Үүнд: нийгмийн ажилтан тэдэнд үнэхээр санаа тавьж, Зовлон зүдгүүр, өвчин шаналал, шударга бус байдал хүнд хэцүү ч тэдгээр нь давуу тал ч болж болно. Бид амьдралынхаа туршид даван туулсан бүхнээс олон сайн арга замуудыг олж, суралцсан байдаг.

туслахыг хүсч байна уу? Туулж өнгөрүүлсэн бүхнийг нь үл хамааран тэднийг хүндэтгэж байна уу? гэх мэт. Хамгийн чухал нь тэд давуу тал, нөөцөө ашиглан өсч дэвшин, асуудлаа даван туулж чадна гэдэгт нийгмийн

ажилтан үнэхээр итгэж байна уу? гэдгийг мэдэхийг хүсдэг.

Нийгмийн ажилтан үйлчлүүлэгчийнхээ хүсэл мөрөөдлийг биелэх, асуудлыг шийдэх боломж, хүч, нөөц үйлчлүүлэгчид өөрт нь байгаа гэдэгт итгэх хэрэгтэй. Энэ нь нийгмийн ажилтан үйлчлүүлэгчээс өндөр хүлээлттэй байж түүнийгээ үйлчлүүлэгчийн хүсэл, зорилго, үнэт зүйл, итгэл найдвартай нь холбох хэрэгтэй гэх зарчим бөгөөд хувь хүн, гэр бүл, бүлэг, олон нийт нь өөрчлөлт шинэчлэлтийг хийх хүч нөөцтэй.

Давуу талд тулгуурлах хандлагын 2 үндсэн суурь философи зарчим байна.

Эрх чөлөөт байдал: Энэ нь боломж, сонголт хийх боломж, хариуцлага, үйлдэл гэсэн үзэл санаан дээр тулгуурласан. Хүнээс хүч энерги, итгэл сэтгэл, шүүмжлэлт сэтгэлгээг шаарддаг.

Итгэл найдвар: Эрх чөлөөтэй байхад боломжид итгэх, найдвартай байх нь чухал. Итгэл найдвар нь зөн билэг, ирээдүйн итгэл, хүмүүс, олон нийт, гэр бүлийн чадвар чадавхийг хүлээн зөвшөөрдөг.

Давуу талд тулгуурлан үйлчилгээ үзүүлэх зарчмууд

1. Үйлчлүүлэгч үйлчилгээ үзүүлж туслахад голлож үзэх зүйлүүд нь тэдний давуу тал, сонирхол, авъяас чадвар, мэдлэг, чадавх юм. Хүмүүсийг тодорхойлох зүйл нь хэн нэгний тавьсан онош, доголдол, асуудал бүхий шинж тэмдэг, сул тал биш юм.

2. Хүмүүст туслах үйл явц бол харилцан туслалцах, хамтын ажиллагаа, түншлэл юм. Эрх мэдэл аль нэгнээсээ давуу байхад бус ижил